

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 21

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/*

6 - 8
- Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудал /Засгийн газар 2026.05.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/*

8 - 21

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, О.Амгаланбаатар, Э.Болормаа, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр, С.Эрдэнэболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Тулга.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны Б.Батцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны дэд сайд С.Даваасүрэн, мөн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Цөмийн

технологийн албаны дарга М.Чадраабал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Ринчинбазар, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Н.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудал /Засгийн газар 2026.05.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Америк, Ойрхи Дорнод, далайн орнуудын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Баттулга, Европ, Африкийн газрын захирал Г.Баттунгалаг, Консулын газрын дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Орших, Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нямдагва нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудлыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Л.Энхнасан, Д.Бум-Очир, Ч.Анар нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Консулын газрын дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Орших нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Австралийн Холбооны Улсын Сидней хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 49 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
12 цаг 35 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Чинбаатарын Анар гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2026 оны 05 сарын 12-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн байна. /алх цохив/

Та бүхэнд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хороо эхний 2 асуудлыг дангаараа хуралдана. Дангаараа хуралдсаны дараагаар Төсвийн байнгын хороотой хамтран хуралдаж шийдвэрлэх нэг асуудал байгаа.

Өнөөдөр хэлэлцэх асуудал.

— **Нэг дэх асуудал.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл.

Засгийн газар 05 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх байгаа.

— **Хоёр дахь асуудал.** Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудал.

Засгийн газар 05 сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн. Зөвшилцөх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн
байнгын хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа Засгийн газрын болоод холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ж.Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн яам, С.Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Дэд сайд, И.Батхүү тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан тус яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Мөнгөнсүх тус яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ тус яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Д.Эрдэнэтуяа тус яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, О.Мягмардорж Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, З.Райымбек Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, П.Чандмань Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас оролцож байна.

Сангийн яамнаас Б.Анар Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга.

Батлан хамгаалах яамнаас С.Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Дэслэгч генерал, Э.Гансүх Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Б.Оюунгэрэл Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байна.

Гадаад харилцааны яамнаас Б.Батцэцэг сайд, Гадаад харилцааны яамнаас мөн Г.Бямбасүрэн Бодлогын газрын захирал, Б.Отгонцэцэг Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Онцгой байдлын ерөнхий газраас Г.Ариунбуян дарга, хошууч генерал, Т.Мөнх-Эрдэнэ тус газрын Санхүүгийн хэлтсийн дарга, дэд хурандаа.

Цөмийн энергийн комиссоос М.Чадраабал ажлын албаны Цөмийн технологийн албаны дарга.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан дарга хүрэлцэн ирсэн байна. Зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Ринчинбазар зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа зөвлөлийн гишүүн, Н.Ууганбаатар зөвлөлийн гишүүн, А.Энхбат зөвлөлийн гишүүн, Н.Энхбаяр гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан байгаа.

Ингээд 1 дүгээр асуудалтай холбоотойгоор Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн тухай хуулийн төслүүдтэй холбогдуулаад зүйл тус бүрээр хэлэлцээд явах байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байгаа юу? Гишүүдийн нэрсийг авъя.

Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Байнгын хорооны гишүүдээс урьдчилж ирүүлээгүй байна.

Алга байна. /алх цохив/

Санал байхгүй байгаа.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх манай Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхээр байгаа.

Ингээд хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулахаар Ч.Анар гишүүн Эдийн засгийн Байнгын хороонд байгаа. Тийм ээ. Та танилцуулчих уу? Тэгье Ч.Анар гишүүнээр танилцуулъя. /алх цохив/

Ингээд хоёр дугаар асуудалдаа оръё.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

**Хоёр.Австралийн Холбооны Улсын Сидней хот,
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо
Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус
нээн ажиллуулах тухай асуудал
/Засгийн газар 2026.05.06-ны өдөр ирүүлсэн,
зөвшилцөх/**

Б.Батцэцэг сайдыг орж иртэл бас тодорхой Их Хурлын чуулганы дэгийн хуралдааны тухай нэг заалттай. Гишүүдээ танилцуулж байя.

Энэ Ерөнхий консулын газар байгуулах тухай асуудлыг Засгийн газраас 05 сарын 06-ны өдөр өргөн барьсан.

Ингээд Дэгийн тухай хуулиар бас нэг ийм заалт байдаг нь чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81.1 дээр хилийн чанадад ажиллах дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо долоо хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана гэсэн бас нэг ийм цаг хугацаатай заалттай юм байна.

Тэгээд бид долоо хоногтоо багтаагаад гишүүдэд материалуудаа шуурхай өргөн барьсан өдөр нь тараасан байгаа.

Ингээд долоо хоногтоо багтаагаад өнөөдөр хэлэлцэж байгаа шүү гэдгийг мэдээлэл болгож хэлэх байна.

Энэ заалт шинээр орж ирсэн заалт байх. Үндсэндээ тодорхой хоног хугацаа үүрэг зохицуулалттай гэж тодорхойлж оруулсан юм байна гэдгийг хэлэх юм байна.

Одоо Б.Батцэцэг сайд орж ирж байх шиг байна.

Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудлын танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг сайд танилцуулна.

Таныг микрофонд урьж байна. 5 номер.

Б.Батцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаадын улс орнуудтай хөгжүүлж байгаа улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэдийн тоо, харилцан зорчих байдал зэргийг харгалзан дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгож, иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг тусгасан.

Үүнтэй холбогдуулан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хот, Австралийн Холбооны Улсын Сидней хотод Ерөнхий консулын газар шинээр нээн ажиллуулах асуудлаар холбогдох судалгааг хийж, Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд холбогдох зардлыг Гадаад харилцааны яамны батлагдсан төсвийн багцад багтаан санхүүжүүлэхээр тусгаад байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёс, чөлөөт зах зээлийн эдийн засаг зэрэг нийтлэг үнэт зүйлс бүхий манай гуравдагч хөрш Европ дахь гол түнш бол, Австралийн Холбооны Улс нь манай улсын Энэтхэг, Номхон далайн бүс нутагт чухал түнш бөгөөд өргөтгөсөн түншлэлийн харилцааг хөгжүүлж байна.

Франкфуртын олон улсын нисэх буудал нь Монгол Улсын иргэдийн гуравдагч оронд зорчихдоо дамжин өнгөрдөг гол зангилаа бүс бөгөөд 2024 онд МИАТ компанийн нислэгээр 42 мянга 500 иргэн зорчсон байна.

Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2025 оны байдлаар 9 мянга орчим монгол иргэн оршин сууж байгаагаас 5300 орчим нь Франкфурт хотын ойролцоо 5 мужид амьдарч байна.

Австралийн Холбооны Улсад 2025 оны байдлаар 24 мянга 650 гаруй монгол иргэн оршин сууж байгаа бөгөөд энэ нь хилийн чанадад оршин сууж байгаа монголчуудын тоогоор гуравдугаарт жагсах үзүүлэлт юм.

Франкфурт, Сидней хотноо Ерөнхий консулын газар шинээр нээн ажиллуулснаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австралийн Холбооны Улстай худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, банк, санхүү, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, Берлин, Канберра дахь Элчин сайдын яамдаас алслагдмал хотуудад амьдарч буй иргэдэд консулын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.

Цаашид хилийн чанад дахь монгол иргэд, тэдгээрийн үүсгэн байгуулсан холбоод хүүхэд, залуучуудад чиглэсэн олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахад шинээр нээх дипломат төлөөлөгчийн газрууд чухал үүрэгтэй юм.

Түүнчлэн шинээр Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрыг нээх асуудлыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австралийн Холбооны Улсын Гадаад хэргийн яамдаас ажлын түвшинд илэрхийлж, дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлсэн болно.

Иймд Франкфурт, Сидней хотноо Ерөнхий консулын газар шинээр нээх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Б.Батцэцэг сайдад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг түрүүн танилцуулсан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах энэ асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. /алх цохив/

Л.Энхнасан гишүүнээр тасаллаа. Д.Бум-Очир гишүүн. Ирцийн дарааллаар юм байна. П.Наранбаяр гишүүн асуулт асууна.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр хүн амын төвлөрөл ихтэй байгаа ийм газруудад консулын үйлчилгээг хүргүүлэх нь зүйтэй.

Тэгээд энэ хүрээнд хоёр асуулт байна.

▷ **Нэгдүгээрт**, Франкфуртад 606 мянган америк доллар, Сиднейд 597 мянган америк долларын санхүүжилт хэрэгтэй гэж тооцсон байна. Үүнийгээ төсөвт хэрхэн тусгах төлөвлөгөөтэй байна вэ?

▷ **Хоёрдугаарт**, Гадаад харилцааны яам Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай хамтраад “Дэлхийн Монголчууд-3” гэж цогц арга хэмжээг зохион байгуулахаар төсөв мөнгөө тавьсан ийм төлөвлөлт оруулж ирж байгаа.

Үүний одоо хэрэгжилт нь, хоёр дахь нь ямар байсан бэ? Тийм ээ. “Дэлхийн Монголчууд-2” цогц арга хэмжээ нь.

Үүнийгээ үргэлжлүүлэх хүрээндээ энэ консулын үйл ажиллагаатай хэрхэн уях вэ? Өөрөөр хэлэх юм бол ер нь цаашдаа бид гадаадад байгаа монгол хүүхдүүд, монгол гэр бүлийн хүүхдүүдэд монгол хэлийг нь заах, монгол хэлийг нь мартуулахгүй байх, монгол хэлийг нь дэмжих, сургалтыг нь дэмжих ийм цогц бодлогыг бас хэрэгжүүлдэг.

Тэгэхээр энэ хүрээнд Гадаад харилцааны яам чухам энэ Ерөнхий консулын газар нээсэнтэй холбогдуулаад үүнийгээ хэрхэн уялдуулан ажиллах бодолтой байна вэ?

Боловсролын яам ч гэсэн энэ ажлыг дэмжиж тухайн үедээ жишээлбэл 2025 онд Чехэд байгаа монгол иргэдийг дэмжсэн санхүүжилтийг өгч тэнд монгол хэлний сургалтын төвийг нээх дэмжлэгийг үзүүлж байсан. Туркт бас байгаа. Ийм байдлаар явдаг.

Тэгэхээр энэ дээр зайлшгүй шаардлагатай яамдтай ажлыг хэрхэн уялдуулах вэ гэдэг энэ зүйлийг асуух гэсэн юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: П.Наранбаяр гишүүн асуулт суулаа. П.Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Б.Батцэцэг сайд 5 номер.

Б.Батцэцэг: Франкфуртэд байгуулах болон Сиднейд байгуулах Консулын газрын зардлыг тус тус 4 орон тоотойгоор төсөвтөө суулгасан байгаа. Энэ жилийн төсөвт орсон байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт, “Дэлхийн Монголчууд-2” хөтөлбөр тодорхой хэмжээнд хэрэгжсэн.

Тэгээд хилийн чанадад суугаа иргэдэд хамаарах Дэлхийн Монголчууд хөтөлбөрт харамсалтай нь өмнөх жилүүдэд төсөв бараг байгаагүй. Одоо тодорхой хэмжээнд бага ч гэсэн жоохон төсөв байгаа.

Тийм учраас хилийн чанадад байгаа 250 орчим төрийн бус байгууллагуудын саналаар, төрийн бус байгууллагуудыг төлөөлсөн холбоонд бид Гадаад харилцааны яаман дээрээ энэ төвдөө өрөө тасалгаа гаргаж өгөөд нэлээн ойрхон ажиллаад, хилийн чанад дахь иргэдийн үүсгэл санаачилгаар байгуулах энэ төрийн бус байгууллагуудтай, Монгол сургуулиудтай, Монгол сургалтын төвүүдтэй маш олон арга хэмжээнүүдийг сүүлийн жилүүдэд зохион байгуулж, тодорхой хэмжээнд анхаарал хандуулснаар нэлээн эерэг өөрчлөлтүүд гарч байгаа.

Тэгэхээр бид “Дэлхийн монголчууд-3” гэдэг хөтөлбөрт зориулаад маш бага зардалтай ч гэсэн хилийн чанадад байгаа монголчуудыг эргэж эх орондоо ирж суурьшихад нь туслах, хилийн чанадад байгаа монгол иргэдийн хүүхдүүдийг монгол хэл болон монгол хэл дээрх сурах бичгээр хангах, сургалтын төвүүдтэй нь бид цахим болон Боловсролын яамтай хамтарсан

хөтөлбөрүүдээ үргэлжлүүлээд хэрэгжүүлж байгаа. Энэ ч гэсэн нэлээд жигдэрсэн явж байгаа.

Монгол судлалыг дэмжих, хилийн чанадад сууж байгаа иргэдийг эргээд эх орондоо ирэхэд нь суурьших, эрх зүйн орчныг нь сайжруулах, энд дасан зохицох хугацаанд нь бас ипотекийн зээл ч юм уу, янз бүрийн байдлаар туслалцаа үзүүлэх тал дээр өнгөрсөн жил бид Үндэсний хороог Засгийн газар дээрээ байгуулж байсан.

Харамсалтай нь үндэсний хороод татан буугдсан хэдий ч энэ чиг үүргийнхээ хүрээнд Гадаад харилцааны яам цаашдаа үргэлжлээд хилийн чанад дахь иргэдийн эрх зүйн байдлыг, эргээд эр эх орондоо суурьшихад нь туслах асуудлуудыг бусад яамдтайгаа хамтраад хийхээр үйл ажиллагааныхаа төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа.

Г.Тэмүүлэн: Б.Батцэцэг сайдад баярлалаа. П.Наранбаяр гишүүн болсон уу? Тийм ээ.

Асуулт асууя. Л.Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Өдрийн мэнд хүргэе.

Австралийн Холбооны Улсын Сидней хот болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээгдэж байгааг дэмжиж байна.

Ялангуяа Монгол Улсын иргэдийн тоо тогтмол энэ хоёр оронд нэмэгдэж байгаа.

Сая төсөвтэй холбоотойгоор П.Наранбаяр гишүүн асуусан учраас.

- Энэ хоёр хотуудад хэчнээн Монгол иргэд ер нь амьдардаг вэ?
- Яг ямар ажил хийдэг вэ?
- Хэчнээн оюутнууд суралцдаг вэ?

Танилцуулга дээр нэг жишээ тавьсан байна.

Франкфурт хотод тухайлбал 2024 онд 320 оюутан ирсэн ба маргаантай асуудал үүссэний улмаас 75 оюутан гэрээгээ эрт цуцалж нутаг буцсан гэж байна.

- Ямар маргаан үүсээд 75 оюутан жишээлбэл нутаг буцсан юм бол?

Сиднейд ч гэсэн албан бусаар нэлээн их монголчууд амьдардаг.

- Хэчнээн иргэд суралцах, эсвэл албан ёсоор ажиллахаар очсон байна?
- Хэчнээн иргэд албан бус, харласан гэх юм уу, тэгж амьдардаг вэ?

- Консул энэ дээр яаж анхаарч ажиллах вэ?
- Цаашдаа яаж ажиллая гэж бодож байгаа вэ?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Л.Энхнасан гишүүнийх. Номер 8 номер. Албан тушаалаа танилцуулаарай.

Т.Бат-Орших: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя.

Консулын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Орших.

2025 оны байдлаар Германд 8962 иргэн оршин сууж байгаа. Үүнээс 5247 иргэн нь Франкфурт хот орчимд амьдарч байна.

Германы хувьд хууль бусаар оршин сууж байгаа иргэдийн тоо харьцангуй цөөн. Дийлэнх нь тэнд хөдөлмөр эрхэлдэг холимог гэр бүлтэй иргэд байгаа.

Австралийн хувьд 2025 оны байдлаар 27 мянга 370 Монгол Улсын иргэн оршин сууж байна. Сидней орчмоор 14 мянга 784 иргэн оршин сууж байгаа.

Сиднейд дийлэнх нь хөдөлмөр эрхлэх визтэй. Дээр нь суралцаж байгаа иргэд байгаа. Мөн Сиднейд дийлэнх нь барилгын салбарт ажиллаж байгаа гэсэн мэдээлэл авсан байгаа.

2024 онд сая таны тодруулсан тэр 75 иргэний асуудлаар жуулчилсан байгууллагын гэрээний маргаантай холбоотой асуудлаар. Очсон байрных нь нөхцөл байдлаас болж түрүүлж гэрээгээ цуцалсан тийм асуудал гарсан.

Канббера дахь Элчин сайдын яамнаас улирал тутам консулын явуулын үйлчилгээг үзүүлж байгаа. Алслагдмал хотуудад консулын үйлчилгээг өнгөрсөн жилийн байдлаар нэг удаагийн явалтаар 200 орчим иргэнд консулын үйлчилгээг хүргүүлж байгаа.

Берлин дэх Элчин сайдын яам мөн ялгаагүй алслагдсан хотуудад байгаа иргэддээ явуулын консулын үйлчилгээгээр төрийн үйлчилгээг хүргэж байгаа.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Сидней хот гэдгээр ер нь яаж сонгосон юм? Яагаад гэвэл Мельбурн чинь нэлээн их Монголчууд ихтэй. Тэр талдаа. Тийм ээ. Энэ нь ямар нэгэн бодлогын чанартай л байх. Тийм ээ?

Г.Тэмүүлэн: 8 номер.

Т.Бат-Орших: Ерөнхийдөө манай иргэд хамгийн их үйлчилгээ авдаг, иргэд маань хамгийн олноор байгаа Сидней хот гэж сонгож байгаа.

Энэ бол манай Канберра дахь Элчин сайдын яамнаас жилд авдаг консулын үйлчилгээ болон тэнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаа нөхцөл байдлыг үндэслэж Сидней гэдэг саналыг оруулж ирж байгаа.

Сиднейтэй ойролцоо хотууд –

- Шинэ Өмнөд Уэльс (New South Wales-NSW) мужид 14 мянга 784 иргэн,
- Виктория (Victoria) мужид 2736 иргэн,
- Күйнслэнд (Queensland) мужид 2662 иргэн,
- Баруун Австрали (Western Australia-WA) мужид 1873 иргэн –

-гээд Сиднейг тойрсон мужуудад иргэд оршин сууж байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Д.Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Нэг мэдээлэл, бас нэг асуулт байна.

Мэдээлэл нь юу гэхээр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсан байгаа.

Ч.Анар гишүүн манай Байнгын хороонд байж байна. Мөн энэ дээр хамтран өргөн барих гэж байна. Энэ дээр ямар өөрчлөлт орсон бэ гэхээр гадаадад байгаа иргэдийн сонгууль өгөх боломжийг нээх тухай асуудал байгаа.

Ер нь энэ нэмэлт, өөрчлөлт дээр, бидний өргөн барьж байгаа нэмэлт, өөрчлөлтөд 3 янзын агуулга байгаа.

- Нэгд нь, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаа.
- Хоёрт нь, урьдчилсан санал авах ажиллагаа.
- Гуравт нь, өөр газарт байгаа сонгогчоос санал авах ажиллагаа –

-гэсэн гурван хэлбэрийн санал авах ажиллагааг Сонгуулийн хуульд оруулж өгөөд, өөрөөр хэлбэл иргэдийн сонгууль өгөх боломжийг нэмэгдүүлэх тухай асуудал байгаа юм.

Яах вэ, бидэнд байгаа тооцоогоор гадаадад үндсэндээ 120 орчим мянган сонгуулийн насны иргэд байгаа.

Тэгээд яг Элчин сайдын яам, консулын газар санал авах байрнаас хол байгаа иргэд байдаг. Тэр дотор яг өнөөдөр яригдаж байгаа 2 хотод Консулын газар байгуулах гэж байна. Энэ 2 хотын нэр бас байдаг.

Бид Гадаад яамнаас мэдээлэл авсан. Ингээд үндсэндээ иргэдийнхээ санал өгөх, сонгуульд оролцох боломжийг нээх үүднээс ийм хуулийн төсөл явж байгаа гэдгийг нэгд мэдээлэл болгоод хэлмээр байна.

Энэ 3 өөрчлөлт орж байгаагийн гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаа гэдэг дээр бид жишээ нь ямар ямар өөрчлөлтийг оруулж өгч байгаа вэ гэхээр –

- Нэгд, урьдчилаад заавал бүртгүүлдэг байсан. Одоо урьдчилсан бүртгэлгүй болох юм.
- Хоёрт, санал тоолох төхөөрөмжөөр саналыг тоолох боломжтой болж байгаа.
- Гуравт, саналын дүнг шууд дамжуулах боломж нээгдэнэ гэж үзэж байгаа.

Өмнө нь 2 хоног авдаг байсан бол 5 хоног авахаар төлөвлөж байгаа.

Элчин сайдын яам, Консулын газар дээр тодорхой хэмжээгээр ачаалал үүсэх байх гэж бид ойлгож байна. Яагаад гэхээр 2 хоног байснаа 5 хоног болохоор тодорхой хэмжээгээр ачаалал үүсэх болов уу гэж бодож байна.

Гадаад яамнаас бид зохих албаны улсуудаас санал авсан. Ерөнхийдөө энэ үйл ажиллагааг дэмжиж оролцоно гэдэг ийм байр суурь өгсөнд юуны өмнө талархаж байгаагаа илэрхийлье.

Бас нэг зүйл. Асуултдаа оръё.

Яах вэ, яг өнөөдөр орж ирж байгаа энэ хоёр асуудлыг дэмжиж байна. Сидней хот болон Франкфурт хотод Консулын газар нээх зайлшгүй шаардлагатай байгаа гэж ойлгож байна. Маш олон монголчуудтай. Хэрэгцээ шаардлага их байдаг.

- Яг ийм хэрэгцээ шаардлага их байгаа өөр ямар ямар хотууд байдаг вэ?
- Дараа нь ямар ямар хотуудын нэрс орж ирэх вэ?
- Төсөв, мөнгийг нь яаж шийдэх вэ?

-гэдэг дээр Та бүхэн хариулт өгнө үү?

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүнд баярлалаа. Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Б.Батцэцэг сайд хариулъя. 5 номер.

Б.Батцэцэг: Юуны өмнө эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлье.

Олон жилийн туршид манай хилийн чанадад байгаа монгол иргэдийн сонгуульд санал өгөх асуудлаар хуулийн төсөл санаачлаад, идэвхтэй хэлэлцээд явж байгаад нь нийт хилийн чанадад байгаа Монголчуудынхаа өмнөөс талархлаа илэрхийлье.

Тэгээд цаашдаа гишүүнийхээ хувиар ч гэсэн дэмжээд оролцоод явах саналтай байгаагаа хэлье.

Хоёрдугаарт, бид яах вэ, энэ жил ер нь Бразилд Элчин сайдын яамаа дахин нээх, Испанид Элчин сайдын яам шинээр нээх, Дублинд буюу Ирландад Консулын газар нээх, Найроби Кени, Өмнөд Африкийн аль нэг улсад Элчин сайдын яам нээх энэ саналууд олон жилийн туршид ярьж байгаа.

Бид бүс нутгийн болон хамтын ажиллагаануудаа үнэлж эрэмбэлж байгаад эдгээр газруудад дипломат төлөөлөгчийн газраа цаашдаа байгуулна гэсэн ийм төлөвлөлттэй явж байгаа.

Тэр дотроо хамгийн түрүүлээд иргэд ихээр оршин сууж байгаа, иргэд тасралтгүй нэмэгдэж байгаа Франкфурт, Сиднейд Ерөнхий консулын газар нээх асуудлыг эхний ээлжид тавьж байгаа.

Мадридад Элчин сайдын яам байгуулах ийм зайлшгүй шаардлага байгаа. Испанийн талаас ч хүлээж авч ойрын хугацаанд нээх энэ хүсэлтийг маань дэмжээд баримт бичгээ зураад, Гадаад яамд хоорондын процедур яваад ерөнхийдөө бэлэн болсон.

Энэ 4 нэрлэсэн газрын дипломат төлөөлөгчийн газар нээх төсвийг уг нь төсөвтөө оруулсан байгаа.

Тэгэхээр дараа нь шатлаад энэ 4 Элчин сайдын яамыг байгуулах төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүн нэмж тодруулъя.

Д.Бум-Очир: Би дэмжиж үг хэлэх гээд байгаа юм.

Монгол Улсын гадаад харилцаа, гадаад бодлого их өргөжиж, гадаад харилцаа нэлээд их тэлснийг манай ард түмэн бид бүгдээрээ мэдэж байгаа.

НҮБ-ын бүртгэлтэй 192 оронтой дипломат харилцаатай болсон. Гадаад арга хэмжээнүүд ар араасаа зохион байгуулагдаж байгаа.

Яг үүнийг дагаад миний ойлгож байгаагаар Гадаад харилцааны яаман дээр гадаад харилцааны чиглэлээр Консулын газар, Элчин сайдын яамдыг нээх хэрэгцээ шаардлага бараг л ар араасаа дараалаад бий болж байгаа болов уу гэж ойлгож байна.

Миний ойлгож байгаа зүйл бол Монгол Улсын гадаад харилцаа урьд өмнө түүхэнд байгаагүй хэмжээгээр өргөжин тэлж байгаа.

Тэгэхээр энд Консулын газар болоод Элчин сайдын яамдыг нээхээс өөр арга зам байхгүй байх. Энэ нь эргээд Монголын гадаад харилцааг өргөжүүлэх маш чухал ач холбогдолтой гэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр дараа дараагийн хэрэгцээ шаардлагатай байгаа... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Минут нэмээд өгье. Д.Бум-Очир гишүүнд.

Д.Бум-Очир: Тийм учраас саяын газрууд Мадрид гээд тэгж байна. Ер нь ойлгож байна. Эд нарыгаа яаралтай оруулж ирээд асуудлаа шийдээд яваарай. Гишүүд дэмжих болов уу гэж ойлгож байна. Монголын ард түмэн ч гэсэн дэмжих болов уу.

Үүнээс бид мөнгө төгрөг, төсөв уг нь харамлах ёсгүй байгаа юм. Монголын нэр нүүр, гадаад харилцаа, тэгээд гурав дахь хөршийн бодлого, цаашлаад ярих юм бол Монголын эдийн засаг болоод тусгаар тогтнолын асуудал ч гэсэн шууд болоод шууд бус утгаар чухал хувь нэмэр оруулж байдаг, Монголын нүүрийг гадаадад тахалж байдаг, иргэддээ үйлчилж байдаг маш олон талын ач холбогдолтой л доо.

Тэгэхээр бид аль болох үүнийгээ дэмжээд явах нь зүйтэй болов уу гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүнд баярлалаа. Санал хэллээ.

Ч.Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Өдрийн мэнд ээ.

Сиднейд болон Франкфуртад нээж байгаа шалгуур. Б.Батцэцэг Та сая Мадридад, Бразилд нээх шаардлагатай байна гээд ярьж байна.

Гадаад хэргийн яам ер нь энэ Ерөнхий консулын газар болон Элчин сайдын яамыг байгуулахдаа ямар шалгууруудыг авч үздэг юм бол?

Иргэдийн оролцоо, эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа, эрх зүйн асуудал.

- Үүнийг харьцуулсан дүгнэлт хийж нээдэг үү?
- Яг ямар шалгуураар хаана шаардлагатай байгаагаа тодорхойлдог вэ?
- Тийм үндсэн индекс ч юм уу, үнэлгээний систем байж энд нээх ёстой гэж үздэг үү?

Энэ хоёр газар маань бусад муж улсуудаа хариуцаж үйлчилгээ үзүүлэх үү гэдэг асуудлыг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, уялдаж байгаа асуудал нь Элчин сайдын яамд, Консулын газрууд ихэвчлэн иргэддээ үйлчилгээ үзүүлж байгаа.

Тэгэхээр энэ хоёр газар маань цаашдаа Гадаад хэргийн яам илүү эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагаа, гадаад харилцааны чиглэлээрээ бас тодорхой хэмжээнд томилогдсон, томилогдох боломжтой тийм хуулийн заалтууд байгаа шүү дээ.

- Тэр чиглэлээрээ үйл ажиллагаа явуулах уу?
- Илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулах чиглэлээр ямар бодлого баримтлах вэ?

-гэсэн хоёр асуултыг асууя.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүний асуултад хариулъя. Б.Батцэцэг сайд 5 номер.

Б.Батцэцэг: Бид Монгол Улсын гадаад харилцаа бүх оронтой дипломат харилцаа тогтоосон.

Бид бүс нутагтаа болон бүх тивд Монгол Улсын төлөөлөл байх ёстой гэж үздэг.

Тэгээд сүүлийн жилүүдэд гадаад харилцаа идэвхжиж байгаатай холбоотой олон төрийн айлчлалууд, албан ёсны айлчлалууд, Гадаад харилцааны сайдын түвшинд, Ерөнхий сайд, Их Хурлын дарга, Ерөнхийлөгчийн түвшинд хийж хэрэгжүүлсэн.

Мэдээж бүх улстай хийж байгаа харилцаандаа үнэлэлт, дүгнэлт өгдөг. Цаашдаа харилцаагаа идэвхжүүлэх шаардлагатай улс төрийн болон эдийн засгийн агуулгаар нь харилцаагаа идэвхжүүлэх тал дээр бид нэлээн идэвхтэй бодлого урт хугацаанд боловсруулж ажиллаж байгаа.

Энэ утгаараа эхний ээлжид ямар ч байсан хилийн чанадад байгаа иргэдийн хөдөлгөөн сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж байгаа. Үүнийгээ дагуулаад бид зарим Элчин сайдын яамд дээр өнгөрсөн жилүүдэд 5 Элчин сайдын яам дээр Консулын хэлтэс нэмж байгуулсан.

Энэ 2 Ерөнхий консулын газар Элчин сайдын яам байгаа оронд нэмээд алслагдсан хотуудад иргэд төрийн үйлчилгээ авч чадахгүй байгаа газрууд дээр ингээд Консулын газрууд байгуулж байгаа.

Мэдээж Консулын газар хэдий ч 4 орон тоотой тус бүр нь. Эдийн засгийн одоо харилцааг хөгжүүлэх, манай бизнес, аж ахуйн нэгжүүдэд тусалж дэмжих, тухайн бүс нутаг, бүс, хотууд, эргэн тойронд байгаа бүхий л хотуудтайгаа бүхий л төрлийн Элчин сайдын яамнаас дутахгүй энэ үйл ажиллагаагаа өргөжүүлэх ийм зорилготой, ийм даалгавартай, ийм чиг үүрэгтэй ажиллана.

Бид Бразил буюу Латин Америкийн орнуудад бид ямар ч Элчин сайдын яам, төлөөлөгчийн газар байхгүй. Бразилд нээж байгаад хаасан байдаг. Эдийн засгийн хүндрэлээс болоод. Энэ нь бидний олон жилийн хөөцөлдөж ярьж, хоёр талдаа тохироод Элчин сайдын яамаа байгуулснаа хаасан нь дипломат харилцаанд нэлээн тийм таагүй үйл явдал болсон.

Тийм учраас түр хугацаагаар хаасан байгаа энэ Элчин сайдын яамаа эргээд нээж ажиллуулах шаардлагатай гэж үзэж байгаа учраас үүнийг төсвийг нь тавиад ингээд Бразилийн Элчин сайдын яамыг дараагийн шатанд оруулахаар бэлтгэсэн байгаа.

Мадридад, Испанид бид олон жил Испанитай харилцах, манай аж ахуйн нэгж, хөдөө аж ахуй, ялангуяа ноос, ноолуурын чиглэлээр, мах, арьс ширний чиглэлээр компаниуд харилцаад ажиллаж байдаг. Испанид бид байгуулах зорилтыг олон жилийн хугацаанд тавьсан. Бас л төсөв, мөнгөний асуудлаас болоод нээж чадахгүй байсан. Үүнийг өнгөрсөн жил сайдын хувьд Испанид айлчлах үеэрээ айлын гадаад яамтай тохироод Элчин сайдын яамаа 6 орон тоотой байгуулахаар тохирсон байгаа.

Мэдээж эдийн засгийн агуулгаараа илүү хамтын ажиллагаа нь Испанийн хувьд маш чухал байгаа.

Ирландад бид Консулын газар байгуулъя. Монголчууд нэлээн олноороо суурьшдаг. Консулын үйлчилгээ их алслагдсан учраас авч чаддаггүй.

Тэгэхээр Ирландад Консулын газрыг бас судалгаа хийгээд байгуулах боломж нөхцөлийг нь айлын талтай ярьсан байгаа.

Африк тивд манайх бас хурдтай хөгжиж байгаа. Эдийн засгийн хувьд хамтарч ажиллах боломжтой. Улс төрийн ч гэсэн ач холбогдолтой гэж үзэж Африкийн Кени Улсыг сонгоод Элчин сайдын яам байгуулах боломжийг судлаад тооцоолол, хамтын ажиллагааны чиглэлүүдээ тодорхойлоод тодорхой хэмжээнд яриа хэлэлцээрийг эхэлсэн байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Консулын газар нээхийг дэмжиж байгаа.

Гол нь Элчин сайд, Консулын газрын дарга, атташе нарт үнэлэлт, дүгнэлт яаж өгдөг вэ? Тэгэхийн тулд тухайн газарт Элчин сайдын яам, Консулын газрыг нээхдээ ямар шалгуураар нээдэг вэ?

Жишээ нь, мэдээж улс төр, гадаад харилцааны шаардлагаар нээж байгаа. Гэхдээ илүү иргэддээ үйлчилгээ хүргэх зорилгоор нээгээд, шалгуур тавиад, түүндээ үр дүнгийн хэмжилт хийдэг үү, эсвэл эдийн засгийн хамтын ажиллагаа үүсгэх шинж чанараасаа нээдэг үү гэдэг шалгуураа анхнаасаа тавих

юм бол эргээд тухайн томилогдсон Элчин сайд болон Консулынхаа үр дүнг дүгнэх бололцоотой болох юм байна гэж би бодоод байгаа юм.

- Тийм шалгуур байдаг уу?
- Түүнийгээ дүгнэдэг үү?

Илүү эдийн засаг хамтын ажиллагаан дээр суурилсан Консулын газар, эсвэл илүү гадаад харилцаан дээр суурилсан Консулын газар гэж нээдэг үү, эсвэл зүгээр одоо шаардлагатай байна гээд... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Дахиад 1 минут өгье.

Ч.Анар: Жишээлэхэд Франкуртад байгаа Консулын газар, Берлинд байгаа Элчин сайдын яамтайгаа адилхан Австри, Швейцарь гэсэн бүс нутгаа хамрах уу гэдэг асуулт байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Асуултад нэмж хариулъя. Б.Батцэцэг сайд 5 номер.

Б.Батцэцэг: Консулын газрууд зөвхөн өөрийнхөө хамаарч байгаа газар нутгийг л хамарна. Өөр улсыг хамрахгүй.

Элчин сайдын яам байхгүй, Консулын хэлтэс байхгүй улс орнуудыг тухайн бүс нутагтаа хариуцдаг Элчин сайдын яамд нь хавсран суудаг. Бүхий л асуудлаар.

Шалгуурын хувьд Элчин сайд нартай сайдын хувьд тусгайлан гэрээ жил болгон байгуулж дүгнэдэг.

- › Эдийн засгийн үзүүлэлт,
- › Үйл ажиллагаа,
- › Улс төр –

-бүхий л чиглэлээр нь үнэлэх ийм тодорхой үнэлэмжүүд байдаг.

Түүгээр нь үнэлгээг нь хийгээд явдаг. Мэдээж яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой.

Дээрээс нь 5, 6 заалтаар Элчин сайд болгонтой гэрээ хийдэг. Тэр үзүүлэлтүүдээр нь жил болгон дүгнээд явдаг.

Өнгөрсөн жилийн Элчин сайд нарын үйл ажиллагааг дүгнэсэн тайлан гарсан байгаа. Үүнийг би Байнгын хорооны гишүүддээ хүргүүлэхэд бэлэн байгаа. Зарим асуудал нь мэдээж хаалттай танилцуулагдах учраас үүнийг гишүүддээ тусгайлан явуулж болно.

Зарим харилцаан дээр зарим үнэлгээ жишээлбэл улс төрийн харилцаа бол юу гэдэг юм хэмжих “Кэй Пи Ай” шиг ч юм уу тодорхой эдийн засгийн

үзүүлэлтүүдээр дүгнэдэг шиг тийм үнэлгээ гардаггүй. Үйл ажиллагааных нь үнэлдэг бас өөрийн аргачлал байдаг.

Тодорхой үр дүн гаргах боломжтой үзүүлэлтүүдээр нь үнэлээд явдаг гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалтыг явуулъя. Тус бүрээр нь санал хураах юм байна.

Нэгдүгээр санал хураалт. Австралийн Холбооны Улсын Сидней хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.8 хувиар дэмжигдсэн байна. /алх цохив/

Хоёр дахь санал хураалт. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.8 хувиар дэмжигдлээ. /алх цохив/

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Энэ асуудлаарх Байнгын хорооноос тэмдэглэл болоод санал, дүгнэлтийг Засгийн газарт шуурхай хүргүүлэх болно.

Ингээд асуудлыг хэлэлцэж дууслаа. Өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан байна. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Үүний дараа хамтарсан хуралдаан байгаа. Гишүүд ирцдээ нэмээд ороод өгөөрэй. Баярлалаа бүгдэд нь. /алх цохив/

Хуралдаан 49 минут үргэлжилж, 13 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД